



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 0311 - 2025/14

Сүхбаатар сум

Түшиг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
Хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.16 дахь заалтад “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.9-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү дүрмийн 5 дахь хэсэгт заасан хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд бүх шатны төсөв захиран зарцуулагчдын үйл ажиллагаанд энэхүү дүрмийн хүрээнд хяналт тавьж болно.” гэж тус тус заасныг үндэслэн Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын /Цаашид Түшиг сумын ИТХ гэх/ -ын санхүүгийн хяналт шалгалтыг нэгдсэн удирдамжийн хүрээнд хийлээ.

Түшиг сумын ИТХ-ын санхүү төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагаа, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой.

Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга, улсын ахлах байцаагч Т.Одсүрэн ахалж, дотоод аудитор Г.Дорждэрэм нарын бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 10-р сарын 03-ны өдрөөс ажлын 7 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Шалгалтад Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ИТХ-ын 2024 он, 2025 оны эхний хагас жилийн санхүү төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагаанд холбогдох баримт материалыг хамрууллаа.

-Байгууллагын үндсэн мэдээлэл

Түшиг сумын ИТХ нь улсын бүртгэлийн 3763544 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131654001 дугаартай дансыг ашиглаж байна.

4325001144

Түшиг сумын ИТХ-ын төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Б. Ариунжаргал, 2-р гарын үсгийг нягтлан бодогч У.Энхнаран нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-д “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн тоог доор дурдсанаар тогтооно”, 37.2.1-д “сумын хүн амын тоо нь 2 000 хүртэл бол 15” гэсэн заалтын хүрээнд тус сумын ИТХ нь 15 төлөөлөгчтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна.

2024 онд ИТХ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 бүлэг 54 заалт бүхий арга хэмжээнээс 53 заалт хэрэгжсэн, биелэлт 98,1 хувьтай байна. Үүнд:Төлөвлөгөөнд тусгагдсан “Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт хийх, үнэлэлт дүгнэлт өгөх ажил хийгдээгүй байна.

2025 онд ИТХ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 6 бүлэг 41 заалт бүхий арга хэмжээ батласанаас эхний хагас жилийн байдлаар 23 заалтаас 20 заалт хэрэгжиж биелэлт 86,9 % хувьтай байна. Үүнд:Төлөвлөгөөнд тусгагдсан “Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт хийх, үнэлэлт дүгнэлт өгөх ажил хийгдээгүй байна.

2024 онд ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдааныг 10 удаа хийж 40 асуудал хэлэлцэн 358 заалт бүхий 40 тогтоол гаргасан бол 2025 эхний хагас жилийн байдлаар хуралдааныг 3 удаа зохион байгуулж 22 асуудал хэлэлцэн 53 заалт бүхий 22 тогтоол гаргасан байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Сумын ИТХ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд сумын иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны 04 дүгээр тогтоолоор ИТХ-ын даргаар С.Түвшинбаярыг, 2024 оны 05 дугаар тогтоолоор зөвлөлийн бүрэлдэхүүнийг 7 гишүүнтэй байхаар байгуулсан байна

Сумын ИТХ нь 15 төлөөлөгчтэй, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо,Төсөв санхүү хөрөнгө оруулалт эдийн засгийн бодлогын хороо, Нийгмийн бодлогын хороо,

Өргөдөл гомдол хууль хяналтын бодлогын хороо зэрэг хурлын хороо байгуулан ажиллуулж, хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Сумын ИТХ-ын ажлын албанаас зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах төсвийн зарцуулалтын эрхийг хурлын нарийн бичгийн даргын тушаалаар бус ИТХ-ын даргын захирамжийг үндэслэн зарцуулах эрх олгосон байна.

Энэ нь МУЗЗНДНТУТ хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтэй байх бөгөөд төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.2. ИТХ-ын бүтэц орон тооны хязгаарыг баримталж ажилласан эсэх, ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

Тус сумын ИТХ-ын дарга нь ажлын албаны бүтэц, орон тоог 2024 онд 03, 06 дугаар, 2025 онд 03 дугаар тогтоолоор 3 албан хаагчтай байхаар тус тус баталсан байна.

Энэ нь Монгол Улсын засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоолоор "...сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг 3 хүртэл байхаар тогтоосугай" гэсэн заалттай нийцэж байна. Цалингийн сангийн зардлыг 2024 онд 107,261.7 мянган төгрөгөөр эцэслэн баталсан бол 2025 онд өмнөх оноос 20.2 хувь буюу 27,120.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь Засгийн газрын 2024 оны 82, 84 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэнтэй холбоотой. Хүснэгт 1. (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | 2024 он | | | | 2025 оны эхний хагас жилийн байдлаар | | | |
|---------------------|--|------------|-------------------|--------------------|-------|--------------------------------------|-------------------|--------------------|-------|
| | | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | /хэтрэлт, хэмнэлт/ | Хувь | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | /хэтрэлт, хэмнэлт/ | Хувь |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 127,745.6 | 122,385.2 | 5,360.4 | 95.8 | 77,102.7 | 70,828.8 | 6,273.9 | 91.9 |
| 210101 | Үндсэн цалин | 101,545.4 | 67,245.8 | 34,299.6 | 66.2 | 32,510.6 | 32,880.1 | (369.5) | 101.1 |
| 210102 | Нэмэгдэл | 21,179.0 | 51,577.7 | (30,398.7) | 243.5 | 36,259.1 | 34,047.5 | 2,211.6 | 93.9 |
| 210104 | Урамшуулал | 5,021.2 | 3,561.8 | 1,459.4 | 70.9 | 8,333.0 | 3,901.3 | 4,431.7 | 46.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,386.5 | 14,165.5 | 2,221.0 | 86.4 | 9,299.4 | 6,904.4 | 2,395.0 | 74.2 |
| Орон тооны мэдээлэл | | 5 | 5 | | | 5 | 5 | | |

2024 он, 2025 оны эхний хагас жилийн байдлаар сумын ИТХ-ын ажлын албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэлд тулган баталгаажуулалт хийхэд: сумын ИТХ-ын

ажлын албаны 3, багийн иргэдийн нийтийн хурал 2, нийт 5 орон тоотойгоор албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалд 2024 онд 127,745.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 122,385.2 мянган төгрөгийг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 16,386.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 14,165.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан бол 2025 онд цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалд 77,102.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 70,828.8 мянган төгрөгийг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 9,299.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 6,904.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйгээс 2025 оны эхний хагас жилийн байдлаар НДШ-д 5,995.0 мянган төгрөгийн өр төлбөр үүссэнг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй байна.

2.3. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2024 онд 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 224,653.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 87.3 хувь буюу 196,151.5 мянган төгрөгийг зарцуулж, 12.7 хувь буюу 28,501.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | /хэтрэлт, хэмнэлт/ | Хувь |
|--------|---|------------------|-------------------|--------------------|--------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 224,653.0 | 196,151.5 | 28,501.5 | 87.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 224,653.0 | 196,151.5 | 28,501.5 | 87.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 214,071.0 | 186,069.6 | 28,001.4 | 86.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 127,745.6 | 122,385.2 | 5,360.4 | 95.8 |
| 210101 | Үндсэн цалин | 101,545.4 | 67,245.8 | 34,299.6 | 66.2 |
| 210102 | Нэмэгдэл | 21,179.0 | 51,577.7 | -30,398.7 | 243.5 |
| 210104 | Урамшуулал | 5,021.20 | 3,561.80 | 1,459.40 | 70.90 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,386.5 | 14,165.5 | 2,221.0 | 86.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,631.0 | 10,393.3 | 1,237.7 | 89.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,168.3 | 1,190.3 | -22.0 | 101.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,948.5 | 2,006.0 | 942.5 | 68.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 638.7 | 575.9 | 62.8 | 90.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,310.3 | 6,030.4 | 279.9 | 95.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,100.6 | 932.0 | 168.6 | 84.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,173.8 | 4,107.5 | 66.3 | 98.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 400.0 | 355.0 | 45.0 | 88.8 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 635.9 | 635.9 | 0.0 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 27,300.0 | 27,299.8 | 0.2 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,300.0 | 20,299.9 | 0.1 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 7,000.0 | 6,999.9 | 0.1 | 100.0 |

| | | | | | |
|--------|---|-----------|-----------|----------|------|
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,066.2 | 2,924.0 | 142.2 | 95.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,066.2 | 2,924.0 | 142.2 | 95.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,300.0 | 3,426.6 | 4,873.4 | 41.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,300.0 | 3,426.6 | 4,873.4 | 41.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,962.4 | 9,838.0 | 15,124.4 | 39.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,000.0 | 4,844.0 | 9,156.0 | 34.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,962.4 | 4,994.0 | 5,968.4 | 45.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,582.0 | 10,082.0 | 500.0 | 95.3 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 10,582.0 | 10,082.0 | 500.0 | 95.3 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 9,582.0 | 9,110.7 | 471.3 | 95.1 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000.0 | 971.3 | 28.7 | 97.1 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 224,653.0 | 196,151.5 | 28,501.5 | 87.3 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 224,653.0 | 196,151.5 | 28,501.5 | 87.3 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 224,653.0 | 196,151.5 | 28,501.5 | 87.3 |

2024 онд:

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 196,151.5 мянган төгрөг буюу 87.3 хувьтай байгаа нь урсгал зардлыг 976,492.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 343,201.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 5,360.4 мянган төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлаас 11,062.0 мянган төгрөгийн, бусад урсгал шилжүүлгээс 56,174.7 мянган төгрөгийн, ажил олгогчийн НДШ-ийн зардлаас 2,221.0 мянган төгрөгийн, хангамж, бараа материалын зардлаас 279.9 мянган төгрөгийн, дотоод албан томилолтоос 142.2 мянган төгрөгийн, тавилга эд хогшлын зардлаас 12,568.1 мянган төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 4,873.4 мянган төгрөгийн, бусад урсгал шилжүүлгээс 500.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 120,790.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 82.7 хувь буюу 99,842.2 мянган төгрөгийг зарцуулж, 17.3 хувь буюу 20,948.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | /хэтрэлт, хэмнэлт/ | Хувь |
|-----|----------|------------|-------------------|--------------------|------|
|-----|----------|------------|-------------------|--------------------|------|

| | | | | | |
|-------------|--|------------------|------------------|----------|-------------|
| II | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 120,790.2 | 99,842.2 | 20,948.0 | 82.7 |
| 21 | Урсгал зардал | 120,790.2 | 99,842.2 | 20,948.0 | 82.7 |
| 210 | Бараа, ажил үйлчилгээний зардал | 106,979.2 | 86,572.2 | 20,407.0 | 80.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 77,102.7 | 70,828.8 | 6,273.9 | 91.9 |
| 210101 | Үндсэн цалин | 32,510.6 | 32,880.1 | -369.5 | 101.1 |
| 210102 | Нэмэгдэл | 36,259.1 | 34,047.5 | 2,211.6 | 93.9 |
| 210104 | Урамшуулал | 8,333.0 | 3,901.3 | 4,431.7 | 46.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,299.4 | 6,904.4 | 2,395.0 | 74.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,071.2 | 4,653.6 | 1,417.6 | 76.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 771.3 | 579.8 | 191.5 | 75.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,016.8 | 576.1 | 440.7 | 56.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 349.5 | 234.9 | 114.6 | 67.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,090.6 | 860.0 | 230.6 | 78.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,753.2 | 1,718.8 | 1,034.5 | 62.4 |
| 210401 | Бичиг хэрэг | 546.0 | 283.5 | 262.5 | 51.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,487.2 | 1,355.3 | 132.0 | 91.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 180.0 | 0.0 | 180.0 | 0.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 540.0 | 80.0 | 460.0 | 14.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,836.9 | 0.0 | 2,836.9 | 0.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,836.9 | 0.0 | 2,836.9 | 0.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,201.0 | 880.0 | 321.0 | 73.3 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,201.0 | 880.0 | 321.0 | 73.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,250.0 | 2,348.3 | 901.8 | 72.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,800.0 | 1,898.3 | 901.8 | 67.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450.0 | 450.0 | 0.0 | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,536.0 | 3,892.0 | 6,644.1 | 36.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,500.0 | 2,561.1 | 4,939.0 | 34.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,036.0 | 1,330.9 | 1,705.1 | 43.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,811.0 | 13,270.0 | 541.0 | 96.1 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 13,811.0 | 13,270.0 | 541.0 | 96.1 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,870.0 | 12,870.0 | 0.0 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 941.0 | 400.0 | 541.0 | 42.5 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 120,790.2 | 112,482.5 | 8,307.7 | 93.1 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 120,790.2 | 112,482.5 | 8,307.7 | 93.1 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 120,790.2 | 112,482.5 | 8,307.7 | 93.1 |

| | | | | | |
|---|---|-----|----------|-----------|--|
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 12,640.3 | -12,640.3 | |
|---|---|-----|----------|-----------|--|

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 6,273.9 мянган төгрөгийн, ажил олгогчийн НДШ-ийн зардлаас 2,395.0 мянган төгрөгийн, хангамж, бараа материалын зардлаас 1,034.5 мянган төгрөгийн, дотоод албан томилолтоос 321.0 мянган төгрөгийн, тавилга эд хогшлын зардлаас 2,836.9 мянган төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжаас 901.8 мянган төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардал 6,644.1 мянган төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлаас 541.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

2.4. Анхан шатны баримтын бүрдэл болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт

ИТХ нь 2024-2025 онд хэрэгжүүлсэн ажил гүйлгээг анхан шатны баримттай тулган үзэхэд зарим нэг ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна. Үүнд:

2024 онд бараа үйлчилгээний бусад зардлаас албан томилолтын зардал 4,490.0 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг, эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, төсвийн зохицуулалт хийх тухай дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг аваагүй байна.

"Зэлтэрийн өгөөж" ХХК-аас төсвийн хөрөнгөөр худалдан авсан 2024 онд 635.9 мянган төгрөгийн, 2025 онд 770.9 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд орлогоор бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан нийт 1,406.8 мянган төгрөгийн худалдан авалт, мөн худалдан авалтын Е төлбөрийн баримтгүй, нэхэмжлэхийн баримтад бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсаргасан 2024 онд 522.9 мянган төгрөгийн, 2025 онд 1,479.4 мянган төгрөгийн, нийт 2,002.3 мянган төгрөгийн худалдан авалт байна.

Эдгээр нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдах, төсвийн сахилга бат, хариуцлага, дотоод хяналтын тогтолцоо сул байгааг, хууль, журмын хэрэгжилт хангагдахгүй байгааг харуулж байна. Иймд худалдан авалт хийх тухай бүрд бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо ширхгээр тусгасан цахим баримтыг бүрдүүлж, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг хангаж ажиллахыг зөвлөв.

2.5 Үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх, өр авлагын барагдуулалт

Төсвийн төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөөгүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас 2025 онд дараах өр, төлбөрийг үүсгэсэн байна

- ✓ 2025 оны эхний хагас жилийн байдлаар НДШ-д 5,995.0 мянган төгрөгийн өр төлбөр үүссэнг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй байна

Төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх, бүртгэл тайланд бүрэн тусгаж байхыг зөвлөв.

2.6 Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэлд тусгасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Үндсэн хөрөнгө: ИТХ нь 2024 оны эхэнд 38,636.0 мянган төгрөгийн /анхны үнээр/ хөрөнгийн үлдэгдэлтэй байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр 20,299.9 мянган төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авч 58,935.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар 58,935.9 мянган төгрөгийн /анхны үнээр/ хөрөнгийн үлдэгдэлтэй байгаагаас машин тоног төхөөрөмж буюу 39205 дугаар дансанд 49,070.9 мянган төгрөгийн 9 хөрөнгө, тавилга аж, ахуйн эд хогшил буюу 39207 дугаар дансанд 9,865.0 мянган төгрөгийн 17 хөрөнгө бүртгэлтэй байна.

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган өмч хамгааллын байнгын зөвлөл болон Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр дахин үнэлэх буюу бүртгэлээс хасах арга хэмжээ аваагүй 3,224.0 мянган төгрөгийн үнэтэй 4 нэр төрлийн 27 ширхэг хөрөнгө байна

Тус ИТХ нь Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалыг данс бүртгэлд орлогоор бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан 2024 онд 4,743.4 мянган төгрөгийн, 2025 онд 2,992.5 мянган төгрөгийн бараа материал байна. Үүнд:

2024 онд:

- ✓ ИТХ-ын төлөөлөгчдийн бичиг хэрэг, цайны материалд 635.9 мянган төгрөг,
- ✓ Шатахуун - 4,107.5 мянган төгрөг,

2025 онд:

- ✓ ИТХ-ын төлөөлөгчдийн бичиг хэрэг, цайны материал – 850.9 мянган төгрөг,
- ✓ Шатахуун – 2,992.5 мянган төгрөг,

Энэ нь Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материал хөрөнгийн тайланд бүрэн тусгаагүйгээс өмч хөрөнгийг шамшигдуулах эрсдэлийг үүсгэж бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна.

2.7 Иргэн, аж ахуй нэгж байгууллагатай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт

Тус сумын ИТХ нь 2024-2025 онуудад төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх томоохон худалдан авалт хийгдээгүй байна. Дараах ажил, арга хэмжээнүүдийн гэрээгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4.

(мянган төгрөгөөр)

| Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл, | Төрөл (бараа, ажил, үйлчилгээ) | 2024.12.31 | 2025.06.30 | Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга |
|---|--------------------------------|------------------------|------------------------|--|
| | | Төсөвт өртөг (мян.төг) | Төсөвт өртөг (мян.төг) | |
| | | | | |

| | | | | |
|--------------------------------------|-----------|------------------|------------------|-----|
| Бичиг хэрэг | Бараа | 1,100.60 | 546.0 | ШГБ |
| Тээвэр шатахуун | Бараа | 4,173.80 | 1,487.20 | ШГБ |
| Багаж, техник, хэрэгсэл | Бараа | 20,300.0 | | ШГБ |
| Урсгал засвар | Ажил | 7,000.0 | | |
| Шуудан холбооны зардал | Үйлчилгээ | 400.0 | 180.0 | ШГБ |
| Баг үнэтэй түргэн элэгдэх | Бараа | 635.9 | 540.0 | ШГБ |
| Бараа үйлчилгээний бусад зардал | Үйлчилгээ | 14,000.0 | 7,500.00 | ШГБ |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал | Үйлчилгээ | 10,962.4 | 3,036.00 | ШГБ |
| Нийт | | 58,572.70 | 13,289.20 | |

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүйгээс 2024 онд шаардлагатай бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлж ажиллаагүйгээс Төсвийн хөрөнгөөр Ай ти сервис ХХК-тай 2024 онд гэрээ байгуулан 19,950.0 мянган төгрөгийн өртөгтэй 15 ширхэг iPad-г цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Цаашид захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авч байхыг зөвлөв.

2.1. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Төрийн аудитын байгууллагаас 2024 онд (2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд) хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 200.0 мянган төгрөгийн төлбөрийн актын биелэлт 100 хувь, 2025 онд (2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд) хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 450.0 мянган төгрөгийн албан шаардлагын биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Түшиг сумын ИТХ-ын 2024 он, 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэргийг тулган шалгахад холбогдох хууль, журам, стандартын дагуу хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна. Үүнд:

Илрүүлэлт 1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйгээс 2025 оны эхний хагас жилийн байдлаар НДШ-д 5,995.0 мянган төгрөгийн өр төлбөр үүссэнг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх, үүссэн НДШ-д 5,995.0 мянган төгрөгийн өр төлбөрийг бүртгэл тайланд тусгаж, өр төлбөрийг барагдуулах **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илрүүлэлт 2. Төсвийн хөрөнгөөр Ай ти сервис ХХК-тай 2024 онд гэрээ байгуулан 19,950.0 мянган төгрөгийн өртөгтэй 15 ширхэг iPad шууд худалдан авч, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шаардлагатай бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4 дэх "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2026 онд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах ХААГ-т хүргүүлж, цаашид цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авч ажиллах **зөвлөмжийг** хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Худалдан авалт нь цахим төлбөрийн баримтаар баталгаажуагүй, нэхэмжлэхийн баримтад бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсаргасан 2024 онд 522.9 мянган төгрөгийн, 2025 онд 1,479.4 мянган төгрөгийн худалдан авалт байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. -д заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалт хийх тухай бүрд бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо ширхгээр орлого авч, цахим баримтаар баталгаажуулж, зарцуулалтаараа зарлагадаж байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Сумын ИТХ-ын ажлын албанаас зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах төсвийн зарцуулалтын эрхийг хурлын нарийн бичгийн даргын тушаалаар бус ИТХ-ын даргын захирамжийг үндэслэн зарцуулах эрх олгосон байна.

Энэ нь МУЗЗНДНТУТ хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтэй байх бөгөөд төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ИТХ-н төсөв санхүүтэй холбоотой шийдвэрийг хурлын ажлын албаны дарга буюу төсвийн шууд захирагч гаргаж байх **зөвлөмж** хүргүүлэв.

Илрүүлэлт 5. Үндсэн хөрөнгийн 39205, 39207 дансанд бүртгэлтэй элэгдлээ бүрэн нөхсөн 0 үлдэгдэлтэй цаашид ашиглалтын жилийн шинэчлэн тогтоож дахин үнэлж үргэлжлүүлэн ашиглах боломжтой 7 нэр төрлийн 30 ширхэг 6,035.0 мянган төгрөгийн үнэтэй хөрөнгүүдийг УСНББОУС-д нийцүүлэн шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-д. "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.", УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө" дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид үндсэн хөрөнгийн 39205, 39207 дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгүүдийн эдийн засгийн үр өгөөжийг тооцон судалгааг гаргаж, орон нутгийн өмчийн газарт саналыг хүргүүлж, УСНББОУС-д нийцүүлэн шийдвэрлэх **зөвлөмж** хүргүүлэв.

Илрүүлэлт 6. ИТХ нь Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалыг данс бүртгэлд орлогоор бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан 2024 онд 4,743.4 мянган төгрөгийн, 2025 онд 2,992.5 мянган төгрөгийн бараа материал байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.2 дахь "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө", 14.4.1 дэх "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ": 14.4.5 дахь "бүх орлого";.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгө материалын орлогыг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж тайлагнаж байх **зөвлөмж** хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Түшиг сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Түшиг сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **41,718.2** мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн зөрчлийг таслан зогсоох **7,997.3** мянган төгрөгийн 2 албан шаардлага, **33,720.9** мянган төгрөгийн 4 зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журамд нийцүүлэн ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа. Үүнд:

- ✓ Санхүүгийн хяналт шалгалтаар материаллаг хэмжээний зөрчил дутагдал илэрч буйд онцгой анхаарч дотоод хяналтын эрчимжүүлэх арга хэмжээг үр дүнтэй зохин байгуулж бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах,
- ✓ Төсвийн хөрөнгийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй байх,
- ✓ Нягтлан бодох бүртгэлийг шууд зардлаар бус аккурэль сууриар УСНББОУС-д нийцүүлэн хөтөлж байх.
- ✓ Үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг цаашид дахин ашиглах боломжтой эсэхийг тогтоож стандартын дагуу бүртгэл тайлагналыг хөтлөх.
- ✓ Төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа хууль тогтоомжид заасан эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэж байх.
- ✓ Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгө материалын орлогыг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж тайлагнаж байх гэсэн зөвлөмжүүдийг төсвийн захирагч, нягтлан бодогч нарт хүргүүлж байна.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 10-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлэхийг тус сумын ИТХ-ын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ДОТООД АУДИТОР




Г.ДОРЖДЭРЭМ

ТАНИЛЦСАН.
ТҮШИГ СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Б.АРИУНЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ



У.ЭНХНАРАН

